

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/148/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25

№

380

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангилал бүрээр бус “бараа үйлчилгээний бусад зардал” ангилалд нэгтгэн төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитаар 30,898.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 22,096.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8,802.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Дархан сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 15 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 80.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>342,504,589.05</u>	<u>375,358,850.78</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	217,338,904.32	237,974,477.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	217,338,904.32	237,974,477.19
3121	Төгрөг	217,338,904.32	237,974,477.19
31211	Төрийн сангийн харилцах	217,338,904.32	237,974,477.19
35	БАРАА МАТЕРИАЛ	125,165,684.73	137,384,373.59
354	Хангамжийн материал	125,085,684.73	137,294,373.59
35410	Бичиг хэргийн материал	102,000.00	3,590,000.00
35420	Аж ахуйн материал	115,935,163.17	120,053,063.17
35470	Бусад хангамжийн материал	9,048,521.56	10,863,810.42
35600	Мал амьтад	80,000.00	90,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,404,354,234.42</u>	<u>1,545,834,413.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,404,354,234.42	1,545,834,413.32
392	Биет хөрөнгө	1,397,461,234.42	1,457,320,413.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,534,449,759.00	1,617,896,554.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(422,625,906.72)	(447,766,357.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,959,162.40	285,259,162.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,902,126.44)	(70,839,659.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,864,179.70	77,033,420.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,511,605.34)	(26,976,458.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,780,400.00	3,780,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,740,790.58)	(2,929,810.62)
39217	Ном	17,188,162.40	21,863,162.40
393	Биет бус хөрөнгө	6,893,000.00	88,513,999.98
39301	Програм хангамж	5,083,000.00	4,723,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(590,000.00)	(705,000.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,400,000.00	84,496,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,746,858,823.47</u>	<u>1,921,193,264.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>73,092,915.00</u>	<u>66,026,756.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,092,915.00	66,026,756.00
413	Өглөг	73,092,915.00	66,026,756.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,092,000.00
4136	Бусад өглөг	73,092,915.00	61,934,756.00
41361	Байгууллагад төлөх өглөг	73,092,915.00	60,206,206.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,673,765,908.47</u>	<u>1,855,166,508.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,673,765,908.47	1,855,166,508.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	215,118,022.00	215,118,022.00
51101	Өмч: - төрийн	215,118,022.00	215,118,022.00
512	Хуримтлагдсан үр дүн	746,948,597.13	928,349,196.76
51210	Өмнөх үеийн үр дүн	746,948,597.13	746,948,597.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	181,400,599.63

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	711,699,289.34	711,699,289.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,746,858,823.47</u>	<u>1,921,193,264.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,218,898,700.00	1,577,806,303.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,085,600.00	182,686,803.10
120	Нийтлэг татварын бус орлого	4,085,600.00	2,581,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,085,600.00	2,581,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,960,100.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,125,500.00	2,581,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	177,462,795.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,643,008.10
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,395,119,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,395,119,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,395,119,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\улсын төсөв\	-	1,248,406,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\орон нутгийн төсөв\	-	146,713,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,214,813,100.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,092,304,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,092,304,900.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,508,200.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,508,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,190,303,079.84	1,396,405,703.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,190,303,079.84	1,394,989,898.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,156,138,457.09	1,379,493,094.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,957,751.79	924,349,673.31
210101	Үндсэн цалин	467,592,300.91	584,819,082.96
210102	Нэмэгдэл	215,138,050.88	289,859,830.35
210104	Урамшуулал	35,567,400.00	49,670,760.00
210105	Гэрээт ажлын хөлс	660,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,886,861.30	115,217,591.08
210201	Тэтгэврийн даатгал	62,271,964.62	79,280,968.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,271,514.03	9,327,172.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,891,660.25	4,572,506.43
210204	Ажилгүйдлийн даатгал	3,448,946.85	4,407,388.72
210205	Эрүүл мэндийн даатгал	14,002,775.55	17,629,554.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,493,277.25	130,123,825.43
210301	Гэрэл, цахилгаан	20,789,177.25	13,706,995.43
210302	Түлш, халаалт	99,484,000.00	113,963,330.00
210303	Цэвэр, бохир ус	1,220,100.00	2,453,500.00
2105	Нормативт зардал	40,869,800.00	83,237,000.00
210502	Хоол, хүнс	40,869,800.00	83,237,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,343,700.00	18,117,195.43
210604	Урсгал засвар	9,343,700.00	18,117,195.43

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,928,194.96	10,131,273.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,960,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,968,094.96	10,131,273.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,658,871.79	92,764,716.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,306,345.00	43,021,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,575,300.00	7,090,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,777,226.79	42,652,616.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,164,622.75	15,496,804.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,415,804.57
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,415,804.57
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,415,804.57
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	1,415,804.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,929,000.00	14,081,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,839,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,090,000.00	14,081,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	235,622.75	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	235,622.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,595,620.16</u>	<u>181,400,599.63</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,716,775.05	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,716,775.05	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(16,716,775.05)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>11,878,845.11</u>	<u>181,400,599.63</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,218,898,700.00</u>	<u>1,397,700,500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,085,600.00	2,581,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,085,600.00	2,581,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,085,600.00	2,581,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,960,100.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,125,500.00	2,581,000.00
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,395,119,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,395,119,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,395,119,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\улсын төсөв\	-	1,248,406,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\орон нутгийн төсөв\	-	146,713,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,214,813,100.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,092,304,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,092,304,900.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,508,200.00	-

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,508,200.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,118,850,478.05</u>	<u>1,370,394,927.13</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,118,850,478.05	1,370,394,927.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,065,356,465.30	1,302,053,922.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,957,751.79	922,696,899.56
210101	Үндсэн цалин	457,524,214.03	568,219,062.41
210102	Нэмэгдэл	224,565,176.52	307,428,193.34
210104	Урамшуулал	36,868,361.24	47,049,643.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,886,861.30	116,606,364.83
210201	Тэтгэврийн даатгал	62,301,786.64	80,224,985.70
210202	Тэтгэмжийн даатгал	7,286,159.86	9,437,692.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,577,195.74	4,634,882.43
210204	Ажилгүйдлийн даатгал	3,510,784.39	4,455,602.22
210205	Эрүүл мэндийн даатгал	14,210,934.67	17,853,201.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,516,777.25	124,711,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,577,177.25	13,706,995.43
210302	Түлш, халаалт	113,696,000.00	108,550,804.57
210303	Цэвэр, бохир ус	1,243,600.00	2,453,500.00
2105	Нормативт зардал	21,540,410.00	31,441,750.00
210502	Хоол, хүнс	21,540,410.00	31,441,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,349,800.00	20,716,195.43
210604	Урсгал засвар	9,349,800.00	20,716,195.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,913,194.96	11,671,273.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,960,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,953,094.96	11,671,273.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,191,670.00	74,210,139.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,303,870.00	67,406,139.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,887,800.00	6,804,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,494,012.75	68,341,004.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,415,804.57
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,415,804.57
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,415,804.57
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	1,415,804.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,258,390.00	66,925,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,168,390.00	52,844,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,090,000.00	14,081,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	235,622.75	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	235,622.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>100,048,221.95</u>	<u>27,305,572.87</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН	-	6,670,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,670,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,670,000.00

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

223001	Бусад хөрөнгө	-	6,670,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(6,670,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	20,635,572.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	217,338,904.32
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	217,338,904.32	237,974,477.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	746,948,597.13	1,673,765,908.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	746,948,597.13	1,673,765,908.47
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	746,948,597.13	1,673,765,908.47
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	746,948,597.13	1,673,765,908.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	746,948,597.13	1,673,765,908.47
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	181,400,599.63	181,400,599.63
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,118,022.00	711,699,289.34	928,349,196.76	1,855,166,508.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,412,499,200.00	1,396,284,695.43	16,214,504.57	98.85
12	Татварын бус орлого	1,412,499,200.00	1,396,284,695.43	16,214,504.57	98.85
120	Нийтлэг татварын бус орлого	4,258,800.00	2,581,000.00	1,677,800.00	60.60
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	4,258,800.00	2,581,000.00	1,677,800.00	60.60
122	Тусламжийн орлого	1,408,240,400.00	1,393,703,695.43	14,536,704.57	98.97
122005	Төсвөөс санхүүжих	1,261,527,100.00	1,248,406,200.00	13,120,900.00	98.96
122005	Төсвөөс санхүүжих	146,713,300.00	145,297,495.43	1,415,804.57	99.03
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,606,330,300.00	1,375,649,122.56	230,681,177.44	85.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,606,330,300.00	1,375,649,122.56	230,681,177.44	85.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,537,034,500.00	1,308,723,922.56	228,310,577.44	85.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,122,789,600.00	922,696,899.56	200,092,700.44	82.18
210101	Үндсэн цалин	676,234,000.00	568,219,062.41	108,014,937.59	84.03
210102	Нэмэгдэл	403,610,200.00	307,428,193.34	96,182,006.66	76.17
210104	Урамшуулал	42,945,400.00	47,049,643.81	(4,104,243.81)	109.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,827,800.00	116,606,364.83	24,221,435.17	82.80

Хэнтий аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	95,762,900.00	80,224,985.70	15,537,914.30	83.77
210202	Тэтгэмжийн даатгал	11,266,200.00	9,437,692.80	1,828,507.20	83.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,633,100.00	4,634,882.43	998,217.57	82.28
210204	Ажилгүйдлийн даатгал	5,633,100.00	4,455,602.22	1,177,497.78	79.10
210205	Эрүүл мэндийн даатгал	22,532,500.00	17,853,201.68	4,679,298.32	79.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,713,300.00	124,711,300.00	2,000.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	13,707,600.00	13,706,995.43	604.57	100.00
210302	Түлш, халаалт	108,552,000.00	108,550,804.57	1,195.43	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,453,700.00	2,453,500.00	200.00	99.99
2105	Нормативт зардал	31,447,500.00	31,441,750.00	5,750.00	99.98
210502	Хоол, хүнс	31,447,500.00	31,441,750.00	5,750.00	99.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,550,800.00	20,716,195.43	1,834,604.57	91.86
210604	Урсгал засвар	22,550,800.00	20,716,195.43	1,834,604.57	91.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,999,100.00	18,341,273.74	657,826.26	96.54
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,999,100.00	18,341,273.74	657,826.26	96.54
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,706,400.00	74,210,139.00	1,496,261.00	98.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,902,400.00	67,406,139.00	1,496,261.00	97.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,804,000.00	6,804,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,295,800.00	66,925,200.00	2,370,600.00	96.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,295,800.00	66,925,200.00	2,370,600.00	96.58
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,214,800.00	52,844,200.00	2,370,600.00	95.71
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,081,000.00	14,081,000.00	-	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(193,831,100.00)	20,635,572.87	(214,466,672.87)	(10.65)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,831,100.00	(20,635,572.87)	214,466,672.87	(10.65)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	193,831,100.00	(20,635,572.87)	214,466,672.87	(10.65)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	217,338,904.32	(217,338,904.32)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	237,974,477.19	(237,974,477.19)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,898.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 82,096.0 мянган төгрөгийн 1 алдааг¹ аудитын явцад залруулж, 8,802.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Залруулсан алдаа

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Газар эзэмших эрхийн /0000363296/ дугаар бүхий гэрчилгээтэй 12248 кв.м газрыг нягтлан бодох бүртгэлд 11048 кв.м-ээр буюу 82,096.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Аудитаар нийт 8,802.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 8,802.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,802.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,670.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 25 хувиар тооцож, журмын дагуу олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь”, “аймаг, нийслэлийн түвшинд 20 хувь”, улс, бүс, олон улсын амжилт гаргасан түвшинд 25 хувь” гэсэн заалтыг зөрчиж, “иж бүрэн байх” нийцсэн бөгөөд зохистой байх”, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”; 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчиж, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газар эзэмших эрхийн /0000363296/ дугаар бүхий гэрчилгээтэй 12248 кв.м газрыг нягтлан бодох бүртгэлд 11048 кв.м-ээр буюу 90,898.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	82,096.0			1	82,096.0	1	82,096.0				
Дүн	1	82,096.0			1	82,096.0	1	82,096.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 25 хувиар тооцож, журмын дагуу олгоогүй байна.	1	8,802.8			1	8,802.8						
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.	1	-			1	-						
Дүн	2	8,802.8			2	8,802.8						